# НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН 2021 ОНЫ АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2021 оны 12 дугаар сарын 20-ны өдөр — Улаанбаатар хот

| д/д | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Хугацаа | Хариуцсан хэрэгжүүлэх хэлтэс, албан тушаалтан | Биелэлт |
|---|---|---|---|---|
| Зорилго-1: Авилгын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчилах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх. | | | | |
| 1 | 1.1 АТГ-аас бэлтгэсэн тв шторк, инфографик, видео график, нийтлэл, теле зохиомж хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг тухайн орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ /фэйсбүүк, твиттер, youtube суваг/, мөн лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр иргэд, олон нийтэд хүргэсэн байх. | Жилдээ | Захиргааны хэлтэс, Мэдээлэл сурталчилгааны хэлтэс, Хүний нөөц, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн | Байгууллагын цахим хуудсанд НЗДТГ-аас гаргасан “Авлигагүй Улаанбаатар” зурагт хуудас болон АТГ-аас бэлтгэсэн Албан тушаалтны ХОМ-тэй танилцах, мэдээлэл өгөх тухай видео танилцуулга байршуулсан. |
| 2 | 1.2 Авилгатай тэмцэх газраас санаачилсан аян, арга хэмжээг байгууллага, салбар нэгж, нутаг дэвсгэрийн онцлогт тохируулан зохион байгуулах. | Жилдээ | Захиргааны хэлтэс, Хүний нөөц, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн | “Зөв зөвд шударга зөв” соён гэгээрүүлэх аяны хүрээнд “Good Habits 20 буюу Зөв дадал 20” дижитал чуулганы хүрээнд хийсэн подкаст нэвтрүүлгийг Авилгатай тэмцэх газрын цахим хуудсаас татан авч албан хаагчдад танилцуулсан. |
| 3 | 1.3 Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах “Шударга ёс, хөгжил дэвшилд 110 мэдээллийн самбар ажиллуулах. | Жилдээ | Захиргааны хэлтэс, Хүний нөөц, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн | Байгууллагын мэдээллийн самбарт Шударга ёс, хөгжил дэвшилд 110 мэдээллийн зурагт хуудсыг байршуулан иргэд үйлчлүүлэгчид мэдээлэл өгсөн. |
| Зорилго-2: Авлигын эсрэг сургалт зохион байгуулах, албан хаагчидаа АТГ-аас зохион байгуулсан сургалтад хамруулах. | | | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 4 | 2.1 Авлигын эсрэг сургалтын санал, захиалгыг төлөвлөгөөндөө тусгуулахаар АТГ-т хүргүүлэх. | Жилдээ | Захиргааны хэлтэс, Хүний нөөц, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн | Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 4.1.1.10.3-т заасан “Авлигын эсрэг сургалт, давтан сургалтыг зохион байгуулах” зорилтын хүрээнд Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсээс зохион байгуулсан “Нийтийн албан тушаалтнуудад зориулсан авлигын эсрэг анхан шатны сургалт”-д газрын удирдах 1, гүйцэтгэх 5 нийт 6 албан хаагч цахимаар хамрагдсан.<br>Сургалтад хамрагдсан албан хаагчид авлигын эсрэг хууль тогтоомж, авлига, ашиг сонирхлын зөрчил, авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаарх мэдлэгээ дээшлүүлсэн. |
| 5 | 2.2 АТГ-аас зохион байгуулдаг авлигын эсрэг анхан болон давтан сургалтад албан хаагчдаа хамруулсан байх. | Жилдээ | Захиргааны хэлтэс, Хүний нөөц, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн | НЗДТГ-аас 2021 оны 01 дүгээр сарын 21-ний өдөр цахимаар зохион байгуулсан мэдүүлэг гаргагч албан тушаалтнуудад зориулсан сургалтад газрын 5 албан хаагчийг хамруулсан. |
| 6 | 2.3 Авлигын эсрэг сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг өөрсдийн нөөц бололцоо, сургагч багшаар дамжуулан иргэд, хүүхэд залуучуудад хүргэх шинэлэг арга хэлбэрээр зохион байгуулж, үр дүнг тооцож, тайлагнасан байх. | Жилдээ | Захиргааны хэлтэс, Хүний нөөц, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн | Газрын албан хаагчдын авлигын эсрэг мэдлэг мэдээллийг нэмэгдүүлэх зорилгоор байгууллагын мэдээлэл солилцох viber, erp.ulaanbaatar.mn системын дундын групп дээр “Ёс зүйн гарын авлага”, мэдээллийг байршуулан албан хаагчдад танилцуулсан. |
| Зорилго-3: Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрийг биелүүлэх, хариуг хугацаанд нь мэдэгдэх. | | | | |
| 7 | 3.1 Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэх. | Жилдээ | Захиргааны хэлтэс, Хүний нөөц, дотоод | Авлигатай тэмцэх газрын 2021 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 05/3435 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | ажил хариуцсан мэргэжилтэн | дугаар албан бичгээр ирүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлсэн. |
| 8 | 3.2 Мөрдөгчийн мэдэгдэл, зөрчил арилгуулах албан бичгийн хүрээнд зохион байгуулсан арга хэмжээг хэрэгжүүлэх, тайланг хүргүүлэх. | Жилдээ | Захиргааны хэлтэс, Хүний нөөц, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн | Албан бичиг ирээгүй болно. |
| Зорилго-4: Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, санаачлага өрнүүлэх. | | | | |
| 9 | 4.1 Авлигын эсрэг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагаас гаргасан санал, санаачлага уриа, аянд нэгдэх. | Жилдээ | Захиргааны хэлтэс, Байгууллагын удирдах албан тушаалтнууд, Хүний нөөц, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн | НЗДТГ-аас гаргасан “Авлигагүй Улаанбаатар” санаачлагын хүрээнд тус газраас олгодог тусгай зөвшөөрлийн хүсэлтийг Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвөөр дамжуулан цахимаар хүлээн авч шийдвэрлэсэн.<br>2021 онд зочид буудал-263, дэн буудал-144, амралтын газар, жуулчны бааз- 91 нийт 498 ахуйн нэгжид үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосон. |
| 10 | 4.2 Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авсан байх. | Жилдээ | Захиргааны хэлтэс, Байгууллагын удирдах албан тушаалтнууд, Хүний нөөц, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн | Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах гэрээ хэлэлцээрт холбогдох албан тушаалтнаар Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 05 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтын дагуу "Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл" гаргуулан ажилласан. |
| Зорилго-5: Авлига ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах. | | | | |
| 11 | 5.1 Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх. /Үйлчилгээг цахимжуулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх/ | Жилдээ | Захиргааны хэлтэс, Байгууллагын удирдах албан тушаалтнууд, Хүний нөөц, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн | Байгууллагын цахим хуудас цахим үйлчилгээний нэгдсэн портал-e-Mongolia-д байгууллагаас олгодог зөвшөөрөл, үйлчилгээний талаарх мэдээллийг байршуулж тухай бүр шинэчилсэн. Мөн тус газраас |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | олгодог тусгай зөвшөөрлийн хүсэлтийг Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвөөр дамжуулан цахимаар хүлээн авч шийдвэрлэн ажилласан. |
| Зорилго-6: Байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг сайжруулах. | | | | |
| 12 | 6.1 Төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл, тусламж, түүний хуваарилалтыг олон нийтэд тухай бүр нь мэдээлэх. | Жилдээ | Мэдээлэл сурталчилгааны хэлтэс, Ахлах нягтлан бодогч | Байгууллагын цахим хуудсанд “төсөв, санхүү” цэсэнд 2021 онд батлагдсан төсөв, санхүү, аудитын тайлан, төсвийн гүйцэтгэлийн мэдээллийг тогтмол шинэчлэн ажилласан. |
| 13 | 6.2 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах. | Жилдээ | Ахлах нягтлан бодогч | Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4 дэх заалтын дагуу байгууллагын цахим хуудасны “шилэн данс” цэсэнд мэдээллийг тогтмол мэдээлсэн. |
| 14 | 6.3 Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.9-д заасан арга хэмжээг заасан хугацаанд албан ёсны цахим хуудас дээрээ байршуулж, иргэд олон нийт үзэж танилцах боломжоор хангах. | Жилдээ | Мэдээлэл сурталчилгааны хэлтэс, Ахлах нягтлан бодогч | Тус газраас хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, явц, байдлын талаарх мэдээллийг цахим хуудсандаа байрлуулсан. |

ХЯНАСАН: ЗАХИРГААНЫ ХЭЛТСИЙН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Х.СОДНОМДЭМБЭРЭЛ

БИЕЛЭЛТ НЭГТГЭСЭН:
МЭРГЭЖИЛТЭН Д.ОЮУН-ЭРДЭНЭ